



"МАКСИМУМЛАЙН" ХЯЗГААРЛАГДМАЛ  
ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИД

СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
БАЙГАЛЬ ОРЧИН,  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

213200 Сүхбаатар сум, Сэлэнгэ аймаг  
Утас/факс: (976) 7036-3653

2024.04.25 № 260  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Дүгнэлт хүргүүлэх тухай

Танай компаниас ирүүлсэн Орхонтуул сумын Рашаант тосгон 1-р багт байрших "Нүхэн жорлонг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих" төслийн материалд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх журмын 3 дахь хэсгийг үндэслэн байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлээ.

Ерөнхий үнэлгээний дүнгээр уг төслийг нөхцөл, болзолтой хэрэгжүүлэх боломжтой гэж үзлээ.

Төсөл хэрэгжүүлэгч байгаль орчинд, нөлөөлөх байдлын үнэлгээг баталснаас хойш 1 сарын дотор тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулан батлуулах, байгаль орчны менежмент төлөвлөгөөний биелэлтийн тайланг тухайн оны 11 дүгээр сарын 01-ний дотор хянан, дараа оны байгаль орчны менежмент төлөвлөгөөг /БОМТ/ батлуулж ажиллахыг анхаарна уу.

Хугацаа хоцроосон бүх төрлийн төсөлд байгаль орчны менежмент төлөвлөгөө батлах, тайлагнах, дүгнэхгүй бөгөөд үйл ажиллагааг зогсоохыг анхааруулж байна.

ОЙН АЛБАНЫ ДАРГА  Г.ЦЭНГЭЛЗАЯА



43130051

## БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ

2024 оны 04 сарын 25

2024/42

Сүхбаатар сум

### ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Төслийн нэр: “Нүхэн жорлонг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих”

Төслийн байршил: Орхонтуул сум Рашаант тосгон 1-р баг

Төсөл хэрэгжүүлэгч: “Максимумлайн” ХХК

Улсын бүртгэлийн дугаар: 9011321046

Регистрийн дугаар: 5538246

Орон нутгийн санал:

Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын Засаг даргын 2024 оны 03-р сарын 11-ны өдрий 01/153 дугаар албан бичгээр ирүүлсэн саналыг харгалзан үзэв.

### ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ

Орхонтуул сумын Рашаант тосгоны Ерөнхий боловсролын сургууль тосгоны нь Орхонтуул сумын Засаг даргын захирамж 2008 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 115 дугаар захирамж бүхий 30961 м<sup>2</sup> талбайд Боловсролын байгууллага зориулалтаар газар эзэмших гэрчилгээтэй.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.2, “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх журам”-ын 2 дахь хэсгийг үндэслэн Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ хийж төслийг “нөхцөл болзолтой”-гоор хэрэгжүүлэх боломжтой гэж үзлээ.

Төслийн ерөнхий үнэлгээний дүгнэлтийг гүйцэтгэлийн ..... хуудсаар гаргав.

## ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУУДАС

Төсөл хэрэгжүүлэгчийн нэр: “Максимумлайн” ХХК  
 Улсын бүртгэлийн дугаар: 9011321046  
 Хувийн хэргийн дугаар: 5538246  
 Регистрийн дугаар: 5538246  
 Төслийн нэр: Нүхэн жорлонг орчин үеийн стандарт,  
 шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих  
 Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, байршил: Орхонтуул сум Рашаант 1-р баг  
 Холбоо барих утас: 99903951

Бодлогын баримт бичгүүд	Ерөнхий үнэлгээний гол шалгуурууд	Нийцсэн, нийцээгүй	Нарийвчлсан үнэлгээ хийх шаардлаг гүй	Үндэслэл тайлбар
Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийн нийцэл	Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа байгаль орчныг хамгаалах болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль тогтоомийн холбогдох заалт	Нийцсэн		Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийн нийцэл, Төрийн бодлого, шийдвэрийн нийцэлийг байгаль орчныг хамгаалах менежмент төлөвлөгөөгөөр тодруулах.
Төрийн бодлого шийдвэрийн нийцэл	Төрөөс баримтлах бодлогын баримт бичиг, стратегийн үнэлгээний дүгнэлт зөвлөмжийн холбогдох заалт	Нийцсэн		
Төслийн байршил түүнтэй холбогдох шалгуурууд	Хуулиар хамгаалагдсан газар нутаг байгаа эсэх /урсац бүрэлдэх эх ойн болон усны бүхий газрын хамгаалалтын бүс, хилийн хамгаалалтын бүс орон нутгийн тусгай хамгаалалттай газар/	нийцсэн		Төсөл хэрэгжиж байршлын ойролцоо гол мөрний урсац бүрэлдэх эх, ойн сангуй.
	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь хүний нөлөө, байгаль цаг уурын еерчлөлтөд эмзэг мэдрэмтгий эсэх	нийцсэн		БОХМТ-нд газрын төлөв байдал хянан баталгааны дүгнэлтэнд заагдсан зөвлөмжийг тусгах.
	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, түүний ойр орчимд улс, орон нутгийн хэтийн хөгжилд ашиглахаар	Нийцсэн		БОМТ-өөр тодруулах.

	төлөвлөсөн сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй газар байгаа эсэх				
	Болзошгүй хуримтлагдах нөлөөлөл үүсгэх эсэх	Нийцээгүй		Хам болон давхардмал нөлөөллүүд хуримтлагдах нөлөөллийг нарийвчлан тогтоолгож БОМТ тусгуулж хэрэгжүүлэх.	
Агаарын чанар					
Төслийн байгаль орчны нөлөөллийн урьдчилсан үнэлгээ	Бохирдуулагч болон аюултай, хортой бодис агаар мандалд ялгаруулах эсэх	Нийцсэн		Агаарт ялгаруулах хорт бодисын хэмжээг тогтмол хянаж, үнэлэлт дүгнэлт өгч, мэргэжлийн байгууллагаар шинжлүүлж байх.	
	Дуу чимээ, доргио чичиргээ, гэрлийн болон дулааны нөлөөлөл цахилгаан соронзон цацраг үүсэх эсэх	Нийцсэн		БОХМТ-өөр тодруулах	
	Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг тодорхойлох. Эдэлбэр газрын болон үйл ажиллагаа явуулж буй хэсгээс хөрсний сорьц дээжийг авч шинжилгээнд хамруулж хяналт тавьж ажиллах.				
	Усан орчин				
	Гадаргын болон газрын доорх усны нөөцийн хомсдол үүсэх эсэх	Нийцсэн		Ажилчдын унд ахуйн усыг ашиглах ба гадаргын болон гүний усны нөөцөд хомсдол үүсгэхгүй	
	Цэнгэг усны нөөцийг ашиглах эсэх	Нийцсэн		Цэнгэг усны нөөцийг ашиглахгүй.	
	Усны тухай хууль тогтоомжийн дагуу уст цэг байгуулах, худаг гаргах цэнгэг усны нөөцийг ашиглах тохиолдолд эрх бүхий байгууллагаар усны дүгнэлт гаргуулах.				
Хөрсөн бүрхэвч					
Хөрс бохирдуулах эсэх	Нийцээгүй	Нийцсэн	Боловсон	00-тэй болох	
	Нүхэн жорлон болон хатуу, шингэн, хог хаягдал техник, технологийн ашиглалтын явцад хөрс бохирдуулахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөх, зардлыг тусгах.				
Нийгмийн нөлөөллийн урьдчилсан үнэлгээ	Нутгийн оршин суугчдын нийгмийн сөрөг нөлөөлөлтэй эсэх	Нийцээгүй		Нутгийн оршин суугчдад нийгмийн сөрөг нөлөөгүй	
	Нөлөөлөлд өртөж болзошгүй төв, суурин газар	Нийцээгүй		Сумын хэтийн төлөвлөгөөтэй уялдуулан дэд бүтцийн холболтыг шийдвэрлэх	

Нэгдсэн дүгнэлт:

“Максимумлайн” ХХК төслийг байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий дүгнэлт хийж төслийг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.2-т заасны дагуу “нөхцөл болзолтой”-гоор хэрэгжүүлэх боломжтой гэж үзлээ.

**Төсөл хэрэгжүүлэхэд мөрдөж ажиллах шаардлагатай нөхцөл болзол:**

305. Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний гүйцэтгэлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах менежмент төлөвлөгөө /БОХМТ/-г үнэлгээ гарснаас 30 хоногийн дотор батлуулах, БОХМТ-өөр тодруулах асуудлууд болон газрын төлөв байдал хянан баталгааны дүгнэлтэнд заагдсан зөвлөмжийг тусгах, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгэж, Байгаль орчин, аялал жуулчлалын газраар жил бүр батлуулж, тайланг тухайн жилийн 11-р сарын 1-ний өдрийн дотор ирүүлж байх,
306. Холбоглох хууль тогтоомжийн дагуу газрын төлбөр, усны төлбөр, хог хаягдлын үйлчилгээний хураамж болон бусад татвар хураамжийг хугацаанд нь төлж байх,
307. Газрыг хөрсний элэгдэл эвдрэлд орохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах,
308. Үйл ажиллагаа эрхлэх явцад ойр орчмын хөрс, ус болон орчны бүсэд ахуйн болон техник тоног төхөөрөмжөөс гарах хатуу болон шингэн хог хаягдал, химийн бодислог шинж чанартай эд материал, түүхий эдийг тусгайлан байгуулсан /байгаль орчинд ил задгай хаягдахгүйгээр/ хогийн цэгт хүргэн төвлөрүүлж байх,
309. Төслийн үйл ажиллагаанаас хий алдагдах, тос тослох материал, тослох материалын хаягдал сав, бохирдсон алчуур, бүх төрлийн түлш, химийн бодис /хор гербицит/ гардаг бол манай газраас аюултай хог хаягдал үүсгэгчийн бүртгэлийн дугаар авч жил бүрийн 12-р сарын 01-ны дотор Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 02-р сарын 02-ны өдрийн А/21 тушаалын дагуу тайланг ирүүлж мэдээллийн санд бүртгүүлж ажиллах,
310. Төслийн нэр, хүчин чадал, байршил өөрчлөгдөх, өргөтгөл, шинэчлэл хийх тохиолдолд байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээг дахин хийлгэх,
311. Цэвэр усны эх үүсвэр, хатуу, шингэн хог хаягдлын асуудлыг төсөлд хэрхэн шийдвэрлэх талаар тодорхой тусгах, байгаль орчинд болон хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөлгүйгээр бүрэн шийдсэний дараа үйл ажиллагааг эхлүүлэх
312. Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.4 дэх заалтийг дагуу эзэмшиж буй газрын 10%-иас доошгүй талбайд мод тарьж, зүлэгжүүлж ургуулах.
- ЗААВАЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ ДЭЭР ДУРЬДСАН АРГА ХЭМЖЭЭГ ЦАГ ХУГАЦААНД НЬ ХАНГАН БИЕЛҮҮЛЭЭГҮЙ ТОХИОЛДОЛД “БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ” МОНГОЛ УЛСЫН ХУУЛИЙН ДАГУУ ХАРИУЦЛАГА НОГДУУЛАХ БОЛНО.**
- Зөвшөөрлийн нөхцөлд заасан арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлэхдээ орон нутгийн захиргааны болон мэргэжлийн байгууллагуудтай нягт хамтран ажиллахыг зөвлөмж болгож байна.

**Онцгойлон анхаарах зүйлс:**

- Төслийн үйл ажиллагаанд доорх зүйлсийг онцгой анхаарч хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:
- Монгол Улсад мөрдөгдөж буй холбогдох хууль, дүрэм журам, норм стандартыг мөрдөх
  - Ногоон байгууламжийг дэмжин ажиллах
  - Химийн бодисын сав, баглаа боодол, үлдэгдэл, хаягдлыг байгаль орчин, хүний эрүүл мэндэд халгүй аргаар цуглуулах, хадгалах, аюулгүй болгох мэргэжлийн байгууллагад хүлээлгэн өгөх
  - Төслийн бүх шатанд, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрмийг ханган ажиллах, ажилтан албан хаагчдыг аюулгүй ажиллагааны талаас материаллаг баазаар сайтар хангах
  - Галын аюулгүй ажиллагааны дүрмийг сайтар ханган, норм стандартыг мөрдөх, тухайн орон нутгийн Онцгой байдлын газартай нягт хамтран ажиллах, гал, гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх багаж, тоног төхөөрөмж, бэлтгэл бэлэн байдлын төлөвлөгөөтэй ажиллах
  - Аюултай хог хаягдал үүсгэгчийн бүртгэлийн дугаар авах. Бүртгэлийн дугаар авсантай холбоотойгоор БОАЖСайдын 2018.02.02-ны өдрийн А/21 тушаалын хавсралт маягтын дагуу

жил бүрийн 12-р сарын 01-ний өдрийн дотор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт ирүүлж байх.

- Аюултай хог хаягдлыг мэргэжлийн байгууллагаар тээвэрлүүлж, устгуулах гэрээ хийж ажиллах.
- Энгийн хог хаягдлыг хуримтлуулах зориулалтын ангилан ялгах цэгтэй байж, эрх бүхий байгууллагатай хог хаягдал зайлуулах гэрээ байгуулж, тогтмол хугацаанд зайлуулж, ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийж бүртгэлжүүлэх, орчин бохирдохоос урьдчилан сэргийлж ажиллах
- Ариун цэврийн байгууламжийг холбогдох стандартын дагуу байгуулах, хөрсөнд нөлөөлөлгүй байх, уламжлалт аргаас татгалзах /Био 00, Эко 00-ийг хэрэглээндээ нэвтрүүлэх болон бусад нөлөөлөл багатай шийдлүүд/.
- Шаардлагатай тохиолдолд онцгой албаны машин, техник хэрэгсэл саадгүй нэвтрэх нөхцөл, боломжийг бүрдүүлэх.
- Хөрсний элэгдэл, эвдрэлийн өнөөгийн байдлыг тодорхойлж, төслийн үйл ажиллагаанаас үүдэн бий болж болзошгүй сөрөг нөлөөлөл түүнээс сэргийлэх болон нөлөөллийг багасгах арга хэмжээ түүнд шаардагдах хөрөнгө зардлыг нарийвчлан тооцох
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулаагүй тохиолдолд ерөнхий үнэлгээг хүчингүйд тооцох бөгөөд Зөрчлийн тухай хуулийн 7.1 дүгээр зүйлийг үндэслэн торгохыг анхаарна уу.
- Ерөнхий үнэлгээнд зааснаас өөр байдлаар тухайн газрыг ашиглахыг хориглоно.

Хянасан: Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний шинжээч:


/Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Ойн албаны дарга /

Гарын үсэг: 

Г.ЦЭНГЭЛЗАЯА

Ерөнхий үнэлгээ хийсэн:

/БОАЖГ-ын Орчны бохирдол, химийн бодис, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хариуцсан мэргэжилтэн/

Гарын үсэг: 

Ц.БҮРЭНБААТАР

Огноо: 2024 оны .....-р сарын ..... өдөр

Ерөнхий үнэлгээний үр дүнг зөвшөөрсөн:

“МАКСИМУМЛАЙН” ХХК

Албан тушаал: Захирал

Овог, нэр: Д.Мөнхнасан

  
МАКСИМУМ ЛАЙН ХХК  
УЛААНБААТАР ХОТ  
1119285379 ☎5538246

Гарын үсэг

Огноо: 2024 оны .....-р сарын ..... өдөр